

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр:	"Адуунчулуун" ХК
Хаяг:	Дорнод аймаг, Хэрлэн сум, 8-р баг, өөрийн байр
Хурал хуралдах өдөр, цаг:	2023.04.26-ны өдөр 14:00 цагт
Хурал хуралдах газар /хаяг, байршил/:	Дорнод аймаг, Хэрлэн сум, 8-р баг, Компанийн өөрийн хурлын зааланд
Хурлын төрөл:	Ээлжит
Хурал зарлагч:	Төлөөлөн Удирдах Зөвлөл
	-
	-
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо:	2023.03.17
Олон нийтэд зарлах огноо:	2023.03.22, 2023.04.06
Бүртгэлийн өдөр:	2023.04.07
Гэрээний дагуу хурлын баримт бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо:	2023.03.27
Хүргүүлсэн огноо:	2023.03.20
Хурлын даргын нэр:	Б.Шатар /ТУЗ-ийн дарга/
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр:	Б.Алтанцэцэг /комиссын дарга/, Э.Давааням, М.Мөнхбаяр, Ж.Анх-Өлзий, Б.Баттөр
Баримт бичгийн жагсаалт /хавсралтаар/:	Хурал хуралдуулах тухай шийдвэр, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх зарын загвар, саналын хуудасны загвар, хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдох мэдээллийн жагсаалт, хурлын дүгнэлт.
Баримт бичгийн хуудасны тоо:	...4... ширхэг
	...13... хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАТЛУУЛАХ КОМИССЫН ДАРГА

Ш. БАЯСГАЛАН/

2023 оны 03 дугаар сарын 20-ны өдөр



**ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛААР ХУРЛААС ГАРАХ
ШИЙДВЭРИЙН ТӨСӨЛД ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭЭС
САНАЛ АВАХ ХУУДАС**



Хувьцаа эзэмшигчийн овог Нэр:

Регистрийн дугаар:

--	--	--	--	--	--	--	--	--	--

Эзэмшиж байгаа хувьцааны төрөл: ширхэг

Хувьцаа эзэмшигчийн үнэт цаасны дансны дугаар:

Үйлчилсэн ҮЦК-ийн нэр:

Үйлчилсэн ҮЦК-ийн ажилтны овог, нэр:

Кумулятив саналын тоо: ширхэг

"Адуунчулуун" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 14:00 цагт Дорнод аймаг, Хэрлэн сум, 8-р баг, компанийн хурлын танхимд болно.

№	Хэлэлцэх асуудлын нэр	Санал авах Шийдвэрийн төсөл	Зөвшөөрсөн Түдгэлзсэн	Татгалзсан	Таны өгөх санал
1	Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн тухай	Тогтоол 23/			
2	Компанийн 2022 оны үйл ажиллагаанд ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэж, батлах тухай	-	-	-	-
3	Компанийн ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн Удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах тухай	Тогтоол 23/			
4	ТУЗ-ийн 2022оны үйл ажиллагааны тайлан	Тогтоол 23/			
5	ТУЗ-ийн үйл ажиллагааны 2023 оны зардал төсвийг батлах.				Нэр дэвшигчдэд өгөх саналын тоо
6	"Адуунчулуун" ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох.				
Ердийн гишүүд:					
1	Б.Шатар	Кумулятив Тогтоол 23/			
2	С.Бадарч				
3	Б.Батсайхан				
4	Ш.Баясгалан				
5	Ш.Идэр				
6	Т.Даваасүрэн				
Хараат бус гишүүд:					
1	Ю.Батбаатар	Кумуля Тогтоол 23/			
2	Б.Ганчулуун				
3	Т.Даш-Эрдэнэ				

Хуудасны ард байгаа САНАМЖ-тай заввал танилцана уу.

Хувьцаа эзэмшигч Гарын үсэг
Брокер Гарын үсэг

/Тамга/ 2023 оны сар өдөр

Саналын хуудас бөглөх САНАМЖ



1. Саналыг ердийн аргаар тоолох асуудалд:

- 1.1 Хувьцаа эзэмшигч нь 1, 3, 4 дугаарт санал өгөхдөө санал өгөх хэсэгт (+) гэсэн тэмдэглэгээг хийнэ. Жишээ нь: Зөвшөөрсөн бол зөвшөөрсөн гэсэн нүдэнд (+), түдгэлзсэн бол түдгэлзсэн гэсэн нүдэнд (+), татгалзсан бол татгалзсан гэсэн нүдэнд (+) тэмдэг тавина.
- 1.2 Хэрэв татгалзсан бол та тухайн асуудлаар гарах шийдвэрийн төсөлд өгөх өөрийн саналаа холбогдох хэсэгт бичнэ үү.
- 1.3 Засварласан, балласан, залруулгатай эсхүл давхар тэмдэглэгээний аль нэгийг хийсэн санал авах хуудас хүчингүйд тооцогдоно.
- 1.4 Хэрэв та Саналын хуудаст энэхүү санамжийн 1.1-т заасан тэмдэглэгээг хийгээгүй бол Түдгэлзсэнд тооцно.
- 1.5 Хэрэв та Саналын хуудсыг буруу бөглөсөн бол Тооллогын комисс нэгтгэсэн дүнг гаргахаас өмнө Саналын хуудсыг дахин авч бөглөж болно.
- 1.6 Хэрэв та хуралд өөрийн биеэр оролцох боломжгүй бол энэхүү санал авах хуудсанд саналаа тэмдэглэн, өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компаниараа дамжуулан манайд илгээнэ үү.
- 1.7 Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч нотариатаар баталгаажуулсан байна.

2. Саналыг кумулятив аргаар тоолох асуудалд:

- 2.1 Хувьцаа эзэмшигч ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшиж буй нэг нэр дэвшигчид бүгдийг, эсхүл хэд хэдэн нэр дэвшигчид хуваан өгөх эрхтэй.

Жишээ нь: Хувьцаа эзэмшигч А нэр бүхий ХК-ийн 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг. Тус компанийн дүрмээр ТУЗ нь 9 гишүүнтэй, үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоожээ. Хувьцаа эзэмшигч А-ийн 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй болно.

Хувилбар А: Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхээ бүгдийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон нэг нэр дэвшигчид өгч болно.

Хувилбар Б: Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхийн 600 эрхээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 эрхээ хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус өгч болно. Хувьцаа эзэмшигч А саналын эрхээ ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон хэд хэдэн нэр дэвшигчид дурын харьцаагаар хуваарилан өгөх эрхтэй.

Тооллогын комиссын бөглөх хэсэг:

Саналын хуудсыг хүчинтэй/ хүчингүйд (доогуур зурах) тооцон тоолсон

Тооллогын комиссын Дарга:

Гишүүн:

Гишүүн:

Гишүүн:

Гишүүн:

Хүчингүйд тооцсон бол шалтгаан

.....

.....

.....

.....



“АДУУНЧУЛУУН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

Компанийн нэр: “Адуунчулуун” хувьцаат компани
Хаяг: Монгол улс, Дорнод аймаг, Хэрлэн сум, 8-р баг
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 14.00 цагт
Компанийн өөрийн хурлын танхимд болно.

Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт
гаргах бүртгэлийн өдөр: 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал:

а. Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн
тухай.

б. Компанийн 2022 оны үйл ажиллагаанд ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэж,
батлах тухай

в. Компанийн ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн Удирдах зөвлөлийн
шийдвэрийг танилцуулах тухай

г. ТУЗ-ийн 2022 оны үйл ажиллагааны тайлан

д. ТУЗ-ийн үйл ажиллагааны 2023 оны зардал төсвийг батлах.

е. “Адуунчулуун” ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбоотой баримт
бичигтэй ТАНИЛЦАХ ГАЗАР, АЖИЛЛАХ ЦАГ:

- Хувьцаа эзэмшигчид 2023 оны 03 дугаар сарын 27-ний өдрөөс 2023 оны 04 дүгээр
сарын 26-ны өдрийг хүртэл өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанидаа хандах, эсвэл
компанийн байранд ирж ирж, хурал зохион байгуулах комисс /Ш.Баясгалан/-т мэдэгдэн
холбогдон хурлын баримт бичигтэй танилцаж болно.

- Хурал зохион байгуулах комисс нь Даваа-Баасан гарагт 08.00-12.00, 13.00-17.00
цагийн хооронд ажиллана.

Хурал зохион байгуулах комиссын дарга, гишүүдийн мэдээлэл:

Дарга: Овог нэр: Ш.Баясгалан
Утас: 89105848

Гишүүн: Овог нэр: А.Оюун-Эрдэнэ
Email: murun@aduunchuluun.mn
Утас: 98686666

Гишүүн: Овог нэр: Г.Батжаргал
Email: g.batjargal@aduunchuluun.mn
Утас: 89991001

Гишүүн: Овог нэр: Э.Мөнхтөр
Email: munkhtur7923@gmail.com
Утас: 99104337

“АДУУНЧУЛУУН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр
Хариуцсан этгээд Хугацаа

№	Хэлэлцэх асуудал	Хариуцсан этгээд	Хугацаа
1	Хурлын ирцийг бүртгэн, хувьцаа эзэмшигч болон хувьцаа эзэмшигчийн төлөөлөгчид саналын хуудас олгох	Тооллогын комисс	10 минут
2	Хурлын ирцийг хуралд танилцуулах	Тооллогын комисс	2 минут
3	Хурлын дарга хурлыг нээж, дэгийг танилцуулах	Хурлын дарга	5 минут
4	Хэлэлцэх асуудлын дарааллын дагуу дараах асуудлуудыг хэлэлцүүлнэ. Үүнд: а. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн тухай. б. Компанийн 2022 оны үйл ажиллагаанд ТУЗ-өөс өгөх дүгнэлт. в. Компанийн ногдол ашиг хуваарилах тухай г. ТУЗ-ийн 2022 оны үйл ажиллагааны тайлан д. ТУЗ-ийн үйл ажиллагааны 2023 оны зардал төсөв. е. “Адуунчулуун” ХК-ийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох.	Хурлын дарга	32 минут
5	Хэлэлцэж буй асуудлуудтай холбогдсон асуулт, хариулт		15 минут
6	Хурлаас гарах шийдвэрийн төслийг танилцуулах	Хурлын дарга	2 минут
7	Хурлаас гарах шийдвэрийн төсөлтэй холбогдсон асуулт, хариулт		5 минут
8	Хуралд биеэр оролцож буй хувьцаа эзэмшигчид болон итгэмжлэлээр оролцож буй этгээдээс саналын хуудсыг хүлээн авах	Тооллогын комисс	2 минут
9	Завсарлага		5 минут
10	Хуралд биеэр оролцож буй хувьцаа эзэмшигчид болон итгэмжлэлээр оролцож буй этгээдээс хурлаас гарах шийдвэрт өгөх саналыг хурлаас гарах шийдвэр бүрээр нэгтгэх	Тооллогын комисс	10 минут
11	Хурлаас гарах шийдвэрийн төсөлд саналын хуудсаар саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийн саналыг тоолж хурлаас гарах шийдвэр тус бүрээр нэгтгэх	Тооллогын комисс	5 минут
12	Хурлаас гарах шийдвэр бүрээр нэгтгэсэн хувьцаа эзэмшигчдийн саналын дүнг тооллогын комиссын тогтоол хэлбэрээр гаргах	Тооллогын комисс	5 минут
13	Тооллогын комиссын тогтоолыг үндэслэн хурлаас гарах тогтоолын төслийг боловсруулах	Тооллогын комисс	10 минут
14	Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах	Тооллогын комисс	5 минут
15	Хурлаас гарах шийдвэрийг танилцуулах	Хурлын дарга	5 минут
16	Хурлыг хаах	Хурлын дарга	2 минут
	Нийт хугацаа		2 цаг



**"АДУУНЧУЛУУН" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ
ХУРАЛДУУЛАХТАЙ ХОЛБОГДУУЛАН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД
ТАНИЛЦУУЛАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 23/05 тоот тогтоол
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг
4. Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлан
5. Компанийн 2022 оны санхүүгийн тайлан
6. Компанийн 2022 оны санхүүгийн тайлангийн талаарх хараат бус аудитын байгууллагын дүгнэлт
7. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлт
8. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн хурлын 23/01 тоот "Ногдол ашиг хуваарилах тухай" тогтоол
9. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайлан
10. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны зардлын төсөв зардлын төсөл
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолын төслүүд
12. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчид, тэдгээрийн танилцуулга
13. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх саналын хуудас

Компанийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.6-д заасан дараах мэдээллийг компанийн цахим хуудас болох <http://aduunchuluun.mn> хаягт байршуулсан тул хувьцаа эзэмшигч Та эдгээр материалтай танилцана уу.

- Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлан
- Компанийн 2022 оны санхүүгийн тайлан
- Компанийн 2022 оны санхүүгийн тайлангийн талаарх хараат бус аудитын байгууллагын дүгнэлт



**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН**

Тооллогын комиссын дарга:

Б.Алтанцэцэг /Цалингийн нягтлан бодогч/

Тооллогын комиссын гишүүд:

Э.Давааням /УТХэлтсийн дарга/

Ж.Анх-Өлзий /Сэлбэг, аж ахуйн нярав/

М.Мөнхбаяр /АЗХДарга/

Б.Баттөр /ЦСТХДарга/

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН**

Зохион байгуулах комиссын дарга:

Ш.Баясгалан /Гүйцэтгэх захирал/

Утас: 89105848

Зохион байгуулах комиссын гишүүд:

А.Оюун-Эрдэнэ /ТУЗ-ийн НБДарга/

Утас: 98686666

Email: murun@aduunchuluun.mn

Н.Ганзориг /IT инженер/

Утас: 95446633

Email: gzohunnu@gmail.com

Г.Батжаргал /ХАБЭА-н инженер/

Утас: 89991001

Email: g.batjargal@aduunchuluun.mn

Э.Мөнхтөр /Уулын хэсгийн дарга/

Утас: 99104337

Email: munkhtur7923@gmail.com



"АДУУНЧУЛУУН" ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2023 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 13/05

Чойбалсан хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал
хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59.4, 59.10, 59.11, 60, 67, 71, 76 дугаар зүйл, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам", "Адуунчулуун" ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

Нэг. "Адуунчулуун" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 14:00 цагт Дорнод аймаг, Хэрлэн сум, 8-р баг, "Адуунчулуун" ХК-ийн хурлын танхимд хуралдуулж дараах асуудлыг хэлэлцүүлэхээр тогтоосугай Үүнд:

- а. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн тухай.
- б. Компанийн 2022 оны үйл ажиллагаанд ТУЗ-өөс өгөх дүгнэлт.
- в. Компанийн ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах тухай.
- г. ТУЗ-ийн 2022 оны үйл ажиллагааны тайлан
- д. ТУЗ-ийн үйл ажиллагааны 2023 оны зардал төсөв.
- е. "Адуунчулуун" ХК-ийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох

Хоёр. Хурал хуралдуулах тухай Хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер, дилерийн компаниудад мэдэгдэх хугацааг 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрөөр, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн хугацааг 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөр тогтоосугай.

Гурав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэн шийдвэрлэх асуудлыг саналын хуудсаар авах бөгөөд саналын хуудасны агуулга, загварыг 01 дүгээр хавсралтаар баталсугай.

Дөрөв. Хувьцаа эзэмшигчээс харьяалагдах үнэт цаасны компаниар нь дамжуулан "Санал авах хуудас"-ыг хүлээн авах сүүлийн өдрийг хурал хуралдах өдөр буюу 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 14⁰⁰ цагийн дотор, мөн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон хувьцаа эзэмшигчээс санал хүлээн авах хугацааг энэ өдрөөр тус тус тогтсугай.

Тав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг энэхүү тогтоолын 02 дугаар хавсралтын дагуу Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас, компанийн өөрийн цахим хуудас, өдөр тутмын сонин хэвлэлд 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдөр тус тус нийтлүүлэхийн зэрэгцээ давтан зарыг 04 дүгээр сарын 06-нд Өдрийн сонин, орон нутгийн Жаран телевиз, сайтад тус тус мэдээлж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг зохион байгуулах комисст хариуцуулсугай.

Зургаа. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулахтай холбогдуулан хурлын дэгийг 03 дугаар хавсралтаар, хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь энэхүү шийдвэрийн 04 дүгээр хавсралтад заасан бичиг баримттай 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрөөс 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр хүртэл 08⁰⁰-17⁰⁰ цагийн хооронд "Адуунчулуун" ХК-ийн байранд ирж танилцах, и-мэйлээр авах эсвэл харьяалагдах Үнэт цаасны компаниас авч танилцах боломжтой болохыг дурдсугай.

Долоо. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Баттогтох овогтой Шатар ТУЗ-ийн дарга/-ыг томилж, тооллогын комисс болон зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг 05 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

Найм. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг 06 дугаар хавсралтаар баталсугай.

Ес. "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай" журмын дагуу хурлын зарыг хүргэж, хурлыг бэлтгэл сайтай явуулахыг хурал зохион байгуулах комисс, ТУЗ-ийн нарийн бичгийн даргад тус тус үүрэг болгосугай.

ДАРГА  Б.ШАТАР



“АДУУНЧУЛУУН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2023 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 23/06

Чойбалсан хот

Компанийн 2022 оны үйл ажиллагааны
болон санхүүгийн тайлангийн талаар
дүгнэлт гаргах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11,
“Адуунчулуун” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.32.5 дахь заалтыг тус тус
үндэслэн **ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛААС ТОГТООХ НЬ:**

Нэг. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд
хийсэн дүгнэлтийг тус тус зөвшөөрсүгэй.

Хоёр. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн
тайлангийн талаарх дүгнэлтийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд
хэлэлцүүлэн батлуулахыг ТУЗ-ийн дарга /Б.Шатар/-д даалгасугай.

ДАРГА



Б.ШАТАР



"АДУУНЧУЛУУН" ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2023 оны 03 сарын 17 өдөр

Дугаар... 23/01

Чойбалсан хот

НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ДҮГНЭЛТ ЗӨВЛӨМЖИЙГ
БАТЛАХ ТУХАЙ

КтХ-ийн холбогдох заалт, нэр дэвшүүлэх хорооны 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 23/01 тоот дүгнэлт зөвлөмжийг үндэслэн Төлөөлөн Удирдах зөвлөлийн хурлаас ТОГТООХ НЬ:

НЭГ. КтХ болон компанийн дүрэмд заасан шалгуур шаардлагыг хангасан мэргэжил, ажлын туршлагыг үндэслэж "Адуунчулуун" ХК-ийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнээр нэр дэвшсэн дараах хүмүүсийн нэрсийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсүгэй. Үүнд:

- | <u>Ердийн гишүүнд:</u> | <u>Хараат бус гишүүнд:</u> |
|------------------------|----------------------------|
| - Б.Шатар | - Ю.Батбаатар |
| - С.Бадарч | - Б.Ганчулуун |
| - Б.Батсайхан | - Т.Даш-Эрдэнэ |
| - Ш.Баясгалан | |
| - Т.Даваасүрэн | |
| - Ш.Идэр | |

ХОЁР. Нэр дэвшигчдийн танилцуулгыг Санхүүгийн Зохицуулах хороо, холбогдох байгууллагууд, төв орон нутгийн хэвлэл мэдээллээр дамжуулан олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулахыг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга А.Оюун-Эрдэнэ-д хариуцуулсугай.

ГУРАВ. Сонгон шалгаруулалтанд тэнцээгүй, олонхийн санал аваагүй нэр дэвшигч нарт хариу мэдэгдэхийг Төлөөлөн Удирдах зөвлөл /А.Оюун-Эрдэнэ/, Нэр дэвшүүлэх хороо /Ө.Амаржаргал/ нарт даалгасугай.

ДАРГА
ГИШҮҮД



Б.ШАТАР
Ө.АМАРЖАРГАЛ
С.БАДАРЧ
Ю.БАТБААТАР
Б.БАТСАЙХАН
Ш.БАЯСГАЛАН
Н.БОЛДРАГЧАА
Ш.ИДЭР
Н.ЭНХЦЭЦЭГ